



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын явцад сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 14 нэрийн, нийт 21,123,500.00 (хорин нэгэн сая нэг зуун хорин гурван мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 18,299,237.31 (арван найман сая хоёр зуун ерэн есөн мянга хоёр зуун гучин долоон төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал А.Батчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001433

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн  
төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Бүртгэж авсан/ Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуримтлагдс ан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Гэдэс вандан	2012.12.07	1	165,000.00	165,000.00	144,375.00	20,625.00
2	Конденшин	2011.12.27	1	330,000.00	330,000.00	324,500.00	5,500.00
3	Төмөр шүүгээ	2011.12.16	5	253,000.00	1,265,000.00	1,265,000.00	0.00
4	Давхар ор /дотуур байр /	2014.12.03	1	440,000.00	440,000.00	297,000.01	142,999.99
5	Цайны газрын ширээ /дотуур байр /	2014.12.03	6	130,000.00	780,000.00	526,500.00	253,500.00
6	Сандал /сургалт байранд/	2013.06.06	31	49,500.00	1,534,500.00	1,265,962.50	268,537.50
7	Гаднах гэрэлтүүгэн хаяг	2012.12.07	1	4,000,000.00	4,000,000.00	3,499,999.65	500,000.35
8	Сандал /өрөөний дотуур байр /	2013.06.06	30	48,000.00	1,440,000.00	972,000.00	468,000.00
9	Цайны газрын сандал /дотуур байр /	2014.12.03	26	50,000.00	1,300,000.00	842,400.00	457,600.00
10	Сауны халаагч тень чулууны хамт	2011.03.30	1	319,000.00	319,000.00	319,000.00	-
11	2-р хоолны тогоо /дотуур байр /	2014.12.03	1	3,420,000.00	3,420,000.00	3,420,000.00	0.00
12	Нам даралтын зуух	2017.12.15	1	2,830,000.00	2,830,000.00	2,122,500.15	707,499.85
13	Шарах шүүгээ /дотуур байр /	2014.12.03	1	650,000.00	650,000.00	650,000.00	0.00
14	Цахилгаан пийшэн /дотуур байр /	2014.12.03	1	2,650,000.00	2,650,000.00	2,650,000.00	0.00
	<b>Нийт дүн</b>		<b>107</b>		<b>21,123,500.00</b> (хорин нэгэн сая нэг зуун хорин гурван мянга таван зуун)	<b>18,299,237.31</b> (арван найман сая хоёр зуун ерэн есөн мянга хоёр зуун гучин долоон төгрөг гучин нэгэн мөнгө)	<b>2,824,262.69</b> (хоёр сая найман зуун хорин дөрвөн мянга хоёр зуун жаран хоёр төгрөг жаран есөн мөнгө)